МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ ХУДАЛДАА
АЖ ҮЙЛДВЭРИЙН ТАНХИМ

ГАРЫН АВЛАГА

ҮНДЭСНИЙ ХЭМЖЭЭНИЙ АЖ АХУЙН НЭГЖҮҮДИЙН МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН СҮЛЖЭЭ TRADEMONGOLIA.MN ВЭБ САЙТ

Сэдэв

НЭВТРЭХ 2
НУУЦ ҮГ СЭРГЭЭХ 4
БАЙГУУЛЛАГАД ЗОРИУЛСАН ХЭСЭГ 5
ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ 6
БАЙГУУЛЛАГЫН МЭДЭЭЛЭЛ 8
МЕНЕЖЕРҮҮД 10
БҮТЭЭГДЭХҮҮН УДИРДАХ 11
МЭДЭЭ 12
БИЗНЕС САНАЛ 14
ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ 16
ТҮГЭЭМЭЛ АСУУЛТ ХАРИУЛТ 18

Цахим шуудан: membership@mongolchamber.mn
Утас: 7727-7070 /2/

НЭВТРЭХ

Хэрэглэгч буюу гишүүн байгууллага нь MYXAYT-аас өгсөн нэвтрэх, нэр нууц үгийг ашиглан TradeMongolia.MN вэб сайтад нэвтэрнэ. Ингэж нэвтэрч орсноор MYXAYT-ын гишүүн танд дараах боломжууд бий болно. Үүнд:

- Хэрэглэгч байгууллагын ерөнхий мэдээллээ засварлах хүсэлт илгээх
- Логогоо шинэчлэх, танилцуулгаа оруулах, газрын зураг дээр хаягийн дагуу байршлаа оруулж өгөх
- Танай байгууллагатай шууд холбоо барих менежерүүдээ оруулах, засах, устгах
- Бүтээгдэхүүн оруулах, засах, устгах
- Үйлчилгээ, арга хэмжээ, бусад байгууллагын үйл явдалтай холбоотой мэдээ, мэдээллээ оруулах, засах, устгах
- Бизнес санал оруулах хүсэлтийг илгээх, засварлах, устгах
- Санал гомдол оруулах хүсэлтийг илгээх, засварлах, устгах

Эдгээрийг хэрхэн, яаж оруулахыг Танд тус гарын авлагаар дамжуулан үзүүлье.

Хуудас тус бүрийн баруун дээд буланд харагдах **Нэвтрэх / Бүртгүүлэх** товчлуур дээр дарж нэвтэрнэ. Доорх зурагт хар өнгөөр хүрээлүүлэн харуулав.



Нэвтрэх / Бүртгүүлэх товчлуур дээр дарахад нэвтрэх цонх онгойх бөгөөд нэвтрэх нэр нууц үгээ оруулан нэвтэрнэ.



Цахим шуудан: membership@mongolchamber.mn
Утас: 7727-7070 /2/

Хэрвээ та вэб сайтад нэвтэрсэн бол Амжилттай нэвтэрлээ гэдэг мэдэгдлийг өгөх ба нэвтэрч чадаагүй тохиодолд хэрэглэгч олдсонгүй, нууц үг буруу байна гэдэг мэдэгдлүүдийг өгөх болно.



Ингээд та энэ үйлдлийг амжилттай хийж гүйцэтгэсэн бол бүх хуудасны баруун дээд буланд харагдах Нэвтрэх / Бүртгүүлэх товчлуурын оронд Танай байгууллагын лого, нэр мөн гарах гэсэн товчлуур харагдаж эхэлнэ.



Цахим шуудан: membership@mongolchamber.mn
Утас: 7727-7070 /2/

НУУЦ ҮГ СЭРГЭЭХ

Вэб сайтад нэвтрэх нэр болон нууц үгийг MYXAYT-аас авна. Нууц үгээ мартсан тохиолдолд байгууллагын регистрийн дугаараа оруулан сэргээх боломжтой ба Танхимд бүртгэлтэй цахим шуудангийн хаягаар шинэчлэсэн нууц үг илгээгдэнэ. Хэрвээ тухайн бүртгэлтэй цахим шуудангийн хаяг буруу эсвэл захиа ирэхгүй байвал Танхимын Гишүүнчлэлийн Газрын 7727-7070 /2/ дугаарт залгах, membership@mongolchamber.mn цахим шуудан хаягаар хүсэлтээ илгээн шинэчлүүлэх боломжтой.





БАЙГУУЛЛАГАД ЗОРИУЛСАН ХЭСЭГ

TradeMongolia.MN вэб сайт дээр хэрэглэгч өөрөө агуулгаа удирдах боломжтой байгууллагад зориулсан хэсэгтэй. Энэ хэсэг рүү орохын тулд та заавал нэвтэрсэн байх шаардлагатай. Хэрвээ нэвтэрсэн тохиолдолд вэб сайтын баруун дээд буланд байрлах байгууллагынхаа логон дээр дарж орно.





Цахим шуудан: membership@mongolchamber.mn
Утас: 7727-7070 /2/

ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

Хэрэглэгч нь өөрийн байгууллагын дараах үндсэн мэдээллүүдийг шинэчлэх хүсэлт илгээх бүрэн боломжтой. Үүнд: Байгууллагын нэр, Регистрийн дугаар, ААН-ийн хэлбэр, Гишүүнчлэлийн ангилал, Цахим шуудангийн хаяг, утасны дугаар, вэб сайт, эдийн засгийн ангилал, салбар, чиглэл зэрэг ерөнхий мэдээллүүд багтана.



Таны зассан үндсэн мэдээлэл вэб сайтад шууд орох боломжгүй ба зөвхөн шинэчлэх хүсэлт илгээгдэнэ. Тус хүсэлтийг вэб сайтын зохицуулагч хүлээн авч тодорхой хугацааны дараа нийтлэхийг анхаарна уу!



Хэрвээ танд хүлээгдэж буй хүсэлт байгаа бол дахин хүсэлт илгээх боломжгүй. Өмнө нь зассаж байсан хүсэлтийн жагсаалтуудаа Гаргасан хүсэлтүүд товчлуур дээр дарж үзэх бүрэн боломжтой. Хүсэлт нь зөвшөөрсөн, татгалзсан 2 төлөвтэй байна.

Цахим шуудан: membership@mongolchamber.mn
Утас: 7727-7070 /2/


EN RU CN
МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ ХУДАЛДАА АЖ ҮЙЛДВЭРИЙН ТАНХИМ
ЭХЛЭЛ БАЙГУУЛЛАГА БҮТЭЭГДЭХҮҮН БИЗНЕС САНАЛ ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ
ТАНАЙ ЛОГО
КОМПАНИЙ НЭР ХХК
Гарах
ТАНАЙ ЛОГО
КОМПАНИЙ НЭР ХХК
Gold member
Байгууллага
Менежерүүд
Бүтээгдэхүүн удирдах
Мэдээ
Бизнес санал
Өргөдөл, гомдол
Үйлчилгээний нөхцөл
Нууц үг солих
Гарах
Таньд хүлээгдэж буй хүсэлт байна. Хариу иртэл дахин хүсэлт илгээх боломжгүй.
ГАРГАСАН ХҮСЭЛТҮҮД
Үндсэн мэдээлэл
Байгууллагын нэр
Регистрийн дугаар
Байгууллагын төрөл
Гишүүнчлэл
И-мэйл
Гар утас
Website
Бөглөөгүй байна
Э/з ангилал
Салбар
Чиглэл
Бусад мэдээлэл
ЗАСАХ


EN RU CN
МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ ХУДАЛДАА АЖ ҮЙЛДВЭРИЙН ТАНХИМ
ЭХЛЭЛ БАЙГУУЛЛАГА БҮТЭЭГДЭХҮҮН БИЗНЕС САНАЛ ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ
ТАНАЙ ЛОГО
КОМПАНИЙ НЭР ХХК
Гарах
ТАНАЙ ЛОГО
КОМПАНИЙ НЭР ХХК
Gold member
Байгууллага
Менежерүүд
Бүтээгдэхүүн удирдах
Мэдээ
Бизнес санал
Өргөдөл, гомдол
Үйлчилгээний нөхцөл
Нууц үг солих
Гарах
БАЙГУУЛЛАГЫН НЭР ХХК Татгалзсан
РЕГИСТРИЙН ДУГААР
ААН-ИЙН ХЭЛБЭР
ЦАХИМ ШУУДАН
УТАСНЫ ДУГААР
ВЭБ САЙТ
2020 - 10 - 27 14:10
БАЙГУУЛЛАГЫН НЭР ХХК Зөвшөөрсөн
РЕГИСТРИЙН ДУГААР
ААН-ИЙН ХЭЛБЭР
ЦАХИМ ШУУДАН
УТАСНЫ ДУГААР
ВЭБ САЙТ
2020 - 10 - 27 14:10
БАЙГУУЛЛАГЫН НЭР ХХК Зөвшөөрсөн
РЕГИСТРИЙН ДУГААР
ААН-ИЙН ХЭЛБЭР
ЦАХИМ ШУУДАН
УТАСНЫ ДУГААР
ВЭБ САЙТ
2020 - 10 - 27 14:21
БАЙГУУЛЛАГЫН НЭР ХХК Зөвшөөрсөн
РЕГИСТРИЙН ДУГААР
ААН-ИЙН ХЭЛБЭР
ЦАХИМ ШУУДАН
УТАСНЫ ДУГААР
ВЭБ САЙТ
2021 - 01 - 05 13:13
БАЙГУУЛЛАГЫН НЭР ХХК Үүсгэсэн
РЕГИСТРИЙН ДУГААР
ААН-ИЙН ХЭЛБЭР
ЦАХИМ ШУУДАН
УТАСНЫ ДУГААР
ВЭБ САЙТ
3 минутын өмнө
TRADEMONGOLIA.MN
ТАНХИМЫН ТУХАЙ
ҮЙЛЧИЛГЭЭ
ТУСЛАМЖ
Мэдээлэл авах

БАЙГУУЛЛАГЫН МЭДЭЭЛЭЛ

Энэ хэсэгт Та байгууллагынхаа лого, танилцуулга, цагийн хуваарь, Facebook, Twitter, YouTube холбоос, байршил зэргийг оруулах, засварлах боломжтой.

1. Логонд тавигдах шаардлага: Лого чанарын шаардлага хангасан JPG эсвэл PNG форматтай, 2 мб-аас доош хэмжээтэй, хамгийн багадаа 200x200 pixel хэмжээтэй зураг оруулна. Эдгээр шаардлагуудыг хангаагүй тохиолдолд систем автоматаар танай байгууллагын логог оруулах боломжгүйг анхаарна уу.
2. Байгууллагын танилцуулгыг текст болон зурган байдлаар оруулах эсвэл текст зураг холигдсон байдлаар оруулах бүрэн боломжтой ба зураг оруулахдаа чанарын шаардлага хангасан JPG эсвэл PNG форматтай, 2 мб-аас доош хэмжээтэй зураг оруулахыг зөвлөж байна.



3. Байгуллагынхаа ажиллах цагийн хуваарийг 09:00 - 18:00 загварын дагуу оруулна. Хэрвээ танай байгууллага Facebook, Twitter, YouTube хуудас, сувагтай бол тэдгээрийн холбоосуудыг оруулж өгөх ба байхгүй тохиолдолд хоосон үлдээнэ. Байгууллагынхаа яг одоогийн хаяг, байршлыг газрын зурагт тодорхой, үнэн зөв зааж өгөх нь чухал бөгөөд бусад хэрэглэгч, зочид танай байгууллагын байршлыг хялбар, хурдан олоход тустай юм. Таны оруулсан лого, танилцуулга, цагийн хуваарь, Facebook, Twitter, YouTube холбоос, газрын зураг дээрх байршил зэрэг нь вэб сайт дээр доорх байдлаар харагдана.



Цахим шуудан: membership@mongolchamber.mn
Утас: 7727-7070 /2/


EN RU CN
МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ ХУДАЛДАА АЖ ҮЙЛДВЭРИЙН ТАНХИМ
ЭХЛЭЛ БАЙГУУЛЛАГА БҮТЭЭГДЭХҮҮН БИЗНЕС САНАЛ ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ
ТАНАЙ ЛОГО
КОМПАНИЙ НЭР ХХК
Гарах
Бусад мэдээлэл
ЗАСАХ
ТАНАЙ ЛОГО
Энэ хэсэгт 200x200 pixel хэмжээтэй зураг оруулна.
Facebook
Twitter
Youtube
Цагийн хуваарь
Байгууллагын танилцуулга *
Код
Загвар
Хэвийн
Үсгийн х...
Хэмжээ
body p
Хаяг *
Байгууллагын хаяг байршлыг доорхи газрын зурагт тэмдэглэнэ үү.
Уртраг(longitude)
106.92
Өргөрөг (latitude)
47.92
Ulaanbaatar
ХАЙХ
Газрын зураг
Хиймэл дагуул
Google
ХАДГАЛАХ

МЕНЕЖЕРҮҮД

Хэрэглэгч өөрийн нэвтрэх нэр, нууц үгийг ашиглан тохиргоо хэсгийн менежерүүд цэсний шинээр нэмэх товчлуурыг дарснаар байгууллагынхаа менежерийг нэмэх боломжтой болно. Ингэснээр танай байгууллагатай бусад зочид, хэрэглэгчид цаг алдалгүй шууд холбоо барих ач холбогдолтой.

Байгууллагынхаа үйл ажиллагаа, бүтээгдэхүүн үйлчилгээг илүү сайн мэддэг зөвлөгөө мэдээллийг цаг алдалгүй тухайн хэрэглэгчдэд хүргэх боломжтой ажилтныг вэб сайтад нэмэхийг та бүхэнд зөвлөж байна.

Бид зөвхөн хэрэглэгчийн мэдээллийг өөрөө бөглөж өгсөн, вэб сайтад нийтлэхийг зөвшөөрсөн тохиолдолд нийтлэнэ. Хэрэглэгч ямар ч тохиолдолд өөрийн хувийн мэдээллийг оруулахаас татгалзаж болно. Бид үйлчилгээний шинэ боломжууд, сурталчилгаа, бусад мэдээллийг цахим хаягаар илгээж болно. Хувь хүн /Менежер/ өөрийн сонголтоор мэдээлэл авахаас татгалзах боломжтой ба Илгээж байгаа цахим шуудангийн агуулга бүрийн төгсгөлд жагсаалтаас хасуулах Unsubscribe гэсэн холбоос бий.





Цахим шуудан: membership@mongolchamber.mn
Утас: 7727-7070 /2/

БҮТЭЭГДЭХҮҮН УДИРДАХ

Танай байгууллагаас санал болгож буй бүтээгдэхүүний танилцуулгыг МҮХАҮТ-ын гишүүнчлэлийн ангилалаас хамааран харилцан адилгүй оруулах боломжтой. Үүнд

- **Standard гишүүн – 5 ширхэг**
- **Gold гишүүн – 15 ширхэг**
- **Platinum гишүүн – 25 ширхэг**
- **Diamond гишүүн – 35 ширхэг**
- **Sponsor гишүүн – 100 ширхэг** бүтээгдэхүүн зураг, текст, тайлбарын хамт тус тус оруулах эрхтэй.

Бүтээгдэхүүний нэр, гарчигийг өгөхдөө зөвхөн тухайн бүтээгдэхүүний оновчтой нэрийг өгөх, нэр болон гарчиг дээр үнэ оруулах эсвэл элдэв урамшуулал, хямдрал, бүтээгдэхүүний тайлбар зэргийг оруулахгүй байх. Бүтээгдэхүүний тайлбар нь зөвхөн тухайн бүтээгдэхүүний тухай дэлгэрэнгүй эсвэл товч мэдээллийг агуулсан байх ба хамааралгүй өөр бүтээгдэхүүний мэдээлэл, сурталчилгаа оруулахгүй байх. Дараах зүйлсийг оруулсан тохиолдолд сайтын Зохицуулагч тухайн бүтээгдэхүүнийг вэб сайтад нийтлэхгүй. Хэрэв бүтээгдэхүүний ангилал нь вэб сайт дахь өөр ангилалд илүү тохиромжтой тохиолдолд үйлчилгээ үзүүлэгч ангилалыг өөрчлөн, тохирох ангилалд нийтлэх эрхтэй. Иймд та бүтээгдэхүүн оруулахдаа ангилалаа зөв сонгож оруулах нь чухал юм. Хэрвээ таны оруулах гэж байгаа бүтээгдэхүүн ангилал сонгох дээр байхгүй бол membership@mongolchamber.mn цахим шуудангийн хаяг болон 7727-7070 утсаар (ажлын өдрүүдэд 09:00 - 17:00 цагийн хооронд) холбогдож мэдээлэл өгөхийг хүсэж байна.

Таны оруулсан бүтээгдэхүүн вэб сайтад шууд орох боломжгүй ба зөвхөн оруулах хүсэлт илгээнэ. Тус хүсэлтийг хүлээн авч вэб сайтын зохицуулагч тодорхой хугацааны дараа нийтлэхийг анхаарна уу!





МЭДЭЭ

Байгууллагаас зохион байгуулсан болон зохион байгуулах гэж буй арга хэмжээ, ярилцлага, мэдээ, мэдээллийг оруулах хүсэлт илгээх, оруулсан мэдээллээ өөрөө удирдах бүрэн боломжтой. Мэдээллийн агуулга нь вэб сайтын [үйлчилгээний нөхцөлийн 3.3, 3.4](#) дэх заалтуудыг хангасан байх мөн үйлчилгээний нөхцөлийн зургаа дахь заалт буюу [хэрэглэгчийн анхаарах зүйлсийг](#) заавал уншиж танилцсан байх шаардлагатай. Мэдээ оруулах хүсэлт нь зөвшөөрсөн, зөвшөөрөөгүй 2 төлөвтэй байна.

Мэдээ, мэдээллийн зураг нь 2 янз байна. **Үүнд:**

1. Мэдээний зураг /Мэдээний зураг нь зураг сонгох товчлуурыг дараад зурагаа сонгосноор зураг болон гарчигийн хамт зочин, хэрэглэгчдэд харагдахийг хэлнэ./



Сонгосон зураг мэдээн дотор хамгийн эхэнд буюу дээд талд гарчиг, огнооны доор харагдана. Доорх зурагт жишээ байдлаар харуулав.



Цахим шуудан: membership@mongolchamber.mn
Утас: 7727-7070 /2/

2. Мэдээлэл доторх зураг. /Тайлбар буюу мэдээлэл оруулах хэсгийн зураг оруулах товчлуурыг ашиглан мэдээн дундаа зурагнууд оруулах боломжтой. 5-аас дээш зураг хавсаргахгүй (оруулахгүй) байхыг анхаарна уу./



Цахим шуудан: membership@mongolchamber.mn
Утас: 7727-7070 /2/

БИЗНЕС САНАЛ

Байгууллагаас байгууллага, байгууллагаас хэрэглэгч рүү хандсан зарын сүлжээнд танай байгууллага өөрт хэрэгтэй бизнес саналуудаа оруулах боломжтой. Ингэж оруулахдаа гарчиг, зураг, текст оруулж болно. Бизнес саналын агуулга нь вэб сайтын уйлчилгээний нөхцөлийн 3.3, 3.4 дэх заалтуудыг хангасан байх мөн үйлчилгээний нөхцөлийн зургаа дахь заалт буюу хэрэглэгчийн анхаарах зүйлсийг заавал уншиж танилцсан байх шаардлагатай. Бизнес санал оруулах хүсэлт нь зөвшөөрсөн, зөвшөөрөөгүй 2 төлөвтэй байна.

Бизнес саналын зураг нь 3 янз байна. **Үүнд:**

1. Бизнес саналын нүүрэнд харагдах зураг



2. Lightbox буюу зурган дээр дарахад томруулж харах боломжтой зураг



Цахим шуудан: membership@mongolchamber.mn
Утас: 7727-7070 /2/

3. Бизнес санал доторх зураг



Бизнес саналын утас оруулах талбарт зөвхөн 1 л утас оруулна. Хэрвээ өөр олон утас оруулах бол текст оруулах талбар дээрээ оруулж өгнө. Хэрхэн оруулж, хэрхэн харагдахыг доорх зурагнаас үзнэ үү.



ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ

“Өргөдөл, гомдол” нь бизнес, бизнесийн орчин дахь хүнд суртал, дарамт шахалт, бизнест учирч буй хүндрэл бэрхшээлийг холбогдох байгууллагад хүргэж шийдвэрлүүлэхийн тулд олон нийтэд хандан дэмжлэг авч МҮХАҮТ-аар дамжуулан дуу хоолойгоо хүргэх зорилго бүхий хэрэглэгч олон нийтэд зориулсан хэсэг юм.

Анхааруулга: Танай байгууллагын оруулсан өргөдөл, гомдол зорилгодоо хүрч олон нийтийн дэмжлэгийг авсан тохиолдолд Танхимаар дамжуулан дуу хоолойгоо хүргэх боломжтой болно. Дэмжигчдийн тоо системээс өгсөн зорилтот тоонд хүрснээр зорилгодоо хүрсэн гэж ойлгоно.

Хэрэглэгчийн оруулсан өргөдөл гомдлыг вэб сайтын зохицуулагч хүлээн авч нийтлэсэн тохиолдолд хэрэглэгч тухай нийтлэсэн өргөдөл, гомдлоо засварлах боломжгүй. Хэрвээ хүлээгдэж буй горимд байгаа тохиолдолд агуулгаа дахин засварлах боломжтой. Өргөдөл гомдлоо оруулахдаа агуулга, зураг, гарчиг зэргийг сайтар нягталж эцсийн байдлаар болсон тохиолдолд хадгалах товчлуурыг дарж илгээхийг анхаарна уу.

Өргөдөл гомдол нь дараах төлөвтэй. **Үүнд:**

- Нийтлэгдсэн
- Зөвшөөрөөгүй
- Хүлээгдэж байна
- Өргөдөл хүргүүлсэн /Танай байгууллагын оруулсан өргөдөл гомдол олон нийтийн дэмжлэг авч зорилгодоо хүрсэн тохиолдолд МҮХАҮТ-аас тухайн байгууллага руу (бизнесийн орчинд хүнд суртал, дарамт шахалт, хүндрэл бэрхшээл гаргаж буй байгууллага) албан тоотоор өргөдөл, гомдлыг тань явуулсан/ нийт 4 төлөвтэй байна.



Мөн зураг оруулах нь 3 янз байна. Үүнд:

1. Нүүрэн харагдах зураг



Цахим шуудан: membership@mongolchamber.mn
Утас: 7727-7070 /2/

2. Lightbox буюу зурган дээр дарахад томруулж харах боломжтой зураг



3. Өргөдөл гомдол дотор харагдах зураг



Өргөдөл гомдлыг хэрхэн ашиглах вэ?

1. Өргөдөл хэдэн дэмжлэг авсаныг өнгө будгаар ялгаж харуулах хэсэг
2. Таны оруулсан өргөдөл, гомдол яг одоогийн байдлаар /тухайн цаг үед/ хэдэн хүний дэмжлэг авсныг харуулах хэсэг
3. Хичнээн хүний дэмжлэг авах зорилго /энэ зорилгыг хэрэглэгч оруулах боломжгүй/
4. Таны оруулсан өргөдөл, гомдлыг бусад зочин, хэрэглэгчид дэмжих товчлуур
5. Олон нийтийн сүлжээнд түгээх товчлуур

Цахим шуудан: membership@mongolchamber.mn
Утас: 7727-7070 /2/

ТҮГЭЭМЭЛ АСУУЛТ ХАРИУЛТ

1. **TradeMongolia.MN вэб сайтад нэгдсэнээр ямар давуу талууд бий болох вэ?**
   - Үндэсний хэмжээний ААН-үүдийн мэдээллийн нэгдсэн сүлжээнд нэгдэх, мэдээллээ эмх цэгцтэй нэг байршилд төвлөрүүлэн нийтэд хүргэх,
   - TradeMongolia.MN вэб сайтыг ашиглан байгууллагынхаа бүтээгдэхүүн үйлчилгээний маркетингийн сувгийг нэгээр нэмэгдүүлэх,
   - Өөрсдийн цахим хаяггүй жижиг дунд аж ахуйн нэгжүүд хувийн орон зайгаа үүсгэх, бараа бүтээгдэхүүн, байгууллагынхаа талаарх нийтлэл, арга хэмжээ, зөвлөмж, ярилцлага, мэдээлэл зэргийг нийтэд мэдээллэх, түгээх, сурталчлах,
   - Өргөдөл гомдолоор дамжуулан бизнесийн орчин дахь хүнд суртал, дарамт шахалт, бизнест учирч буй хүндрэл бэрхшээлийг холбогдох байгууллагад хүргэхийн тулд олон нийтэд мэдээллэн дэмжлэг авч MYXAYT-аар дамжуулан тухайн байгууллагад дуу хоолойгоо хүргэх,
   - Хэрэглэгч өөрийн оруулсан бүх мэдээллийг засварлах, устгах, удирдах бүрэн боломжтой
   - Бусад ААН байгууллага, хувь хүмүүстэй холбоо тогтоох, харилцан хамтран ажиллах бизнесийн төрөл бүрийн санал тавих,
   - Нэмэлт төлбөр төлж бараа бүтээгдэхүүн, байгууллагаа онцолж харуулах,
2. **Байгууллагынхаа мэдээллийг хэрхэн вэбсайтад байршуулах вэ?**
   - MYXAYT-ын гишүүнчлэлийн анкетыг бөглөж гишүүн болсноор trademongolia.mn вэб сайтын хэрэглэгч болох ба дараах ерөнхий мэдээллүүдийг уг сайтад байршуулна. Үүнд:
     - Эдийн засгийн ангилал
     - Салбар, чиглэл
     - Аймаг/хот, сум/дүүрэг
     - ААН-ийн хэлбэр
     - Байгууллагын утас
     - Цахим шуудангийн хаяг
     - Хаяг, байршил
     - Ажиллах цагийн хуваарь
     - Олон нийтийн сүлжээний хаягууд
3. **Байгууллагынхаа мэдээллийг хэрхэн шинэчлэх вэ?**
   - MYXAYT-ын гишүүнчлэл хариуцсан ажилтнаас авсан нэвтрэх нэр, нууц үгийг ашиглан тохиргоо хэсгийн үндсэн мэдээлэл засах цонхыг бөглөж хүсэлтийг илгээснээр тодорхой хугацааны дараа мэдээллийг шинэчлэх боломжтой.
4. **Танилцуулгаа хэрхэн оруулах вэ?**
   - Хэрэглэгч өөрийн нэвтрэх нэр, нууц үгийг ашиглан тохиргоо хэсгийн бусад мэдээллийг засах цонхыг нээснээр байгууллагын лого, цагийн хуваарь, олон нийтийн сүлжээний холбоосууд, газрын зураг мөн байгууллагынхаа танилцуулгыг засварлах боломжтой болно.
5. **Мэдээлэл, үйлчилгээг хэрхэн оруулах вэ?**
   - Хэрэглэгч өөрийн нэвтрэх нэр, нууц үгийг ашиглан тохиргоо хэсгийн мэдээ цэсний шинээр нэмэх товчлуурыг дарснаар мэдээлэл оруулах хүсэлтээ admind илгээж болно. Мэдээлэл үйлчилгээ нь хүлээгдэж буй мэдээлэл, нийтлэгдсэн мэдээлэл гэсэн төлөвтэйгээр харагдана.
6. **Байгууллагын менежер нэмэх нь ямар ач холбогдолтой вэ? Ямар ажилтныхаа мэдээллийг оруулах нь зохистой вэ?**
   - Хэрэглэгч өөрийн нэвтрэх нэр, нууц үгийг ашиглан тохиргоо хэсгийн менежерүүд цэсний шинээр нэмэх товчлуурыг дарснаар байгууллагынхаа менежерийг нэмэх боломжтой болно. Ингэснээр танай байгууллагатай бусад зочид, хэрэглэгчид цаг алдалгүй шууд холбоо барих ач холбогдолтой. Байгууллагынхаа үйл ажиллагаа, бүтээгдэхүүн үйлчилгээг илүү сайн мэддэг зөвлөгөө мэдээллийг цаг алдалгүй тухайн хэрэглэгчдэд хүргэх боломжтой ажилтныг вэб сайтад нэмэхийг MYXAYT-аас та бүхэнд зөвлөж байна.
7. **Олон бүтээгдэхүүн оруулах боломжтой юу?**
   - MYXAYT-ын гишүүнчлэлийн ангилалаас хамааран бүтээгдэхүүн оруулах тоо харилцан адилгүй байна.
8. **Газрын зураг дээр байгууллагын хаяг байршлыг хэрхэн нэмж оруулах вэ?**
   - Хэрэглэгч өөрийн нэвтрэх нэр, нууц үгийг ашиглан тохиргоо хэсгийн байгууллага цэсний бусад мэдээллийг засах товчлуурыг дарснаар газрын зураг дээр байгууллагын байршилыг зааж өгнө.
9. **Таны оруулсан мэдээлэл вэб сайтад шууд нийтлэгдэх үү?**
   - Таны оруулсан мэдээлэл үйлчилгээ, бүтээгдэхүүн, бизнес санал, өргөдөл гомдол вэб сайтад шууд орох боломжгүй ба зөвхөн оруулах хүсэлт илгээнэ. Тус хүсэлтийг хүлээн авч вэб сайтын зохицуулагч тодорхой хугацааны дараа нийтлэхийг анхаарна уу!
10. **Вэб сайтад нийтлэсэн мэдээллийг цааш нь түгээж болох уу?**
    - Тухайн вэб сайтад нийтлэгдсэн ямар ч мэдээллийг хэрэглэгч, зочид түгээж болох ба олон нийтийн сүлжээнд оруулах товчлуурыг ашиглан түгээх боломжтой.
11. **Хэрэглэгч оруулсан мэдээллүүдээ засах боломжтой юу?**
    - Хэрэглэгч өөрийн оруулсан бүх мэдээллийг засварлах, устгах, удирдах бүрэн боломжтой.
12. **Хэрэглэгч нэвтрэх нэр нууц үгээ хаанаас авах вэ?**
    - Хэрэглэгч MYXAYT-ын танхимд гишүүнээр элсэж албан ёсны гишүүнчлэлтэй болсноор TradeMongolia.MN вэб сайтад нэвтрэх эрх үүснэ. Нэвтрэх нэр, нууц үгийг Танхимын Гишүүнчлэлийн газраас таны цахим шуудангийн хаяг руу илгээх болно.

Цахим шуудан: membership@mongolchamber.mn
Утас: 7727-7070 /2/

13. Нууц үгээ мартсан бол хэрхэн сэргээх вэ?

- Хэрвээ хэрэглэгч нууц үгээ мартсан бол хэрэглэгчийн нэвтрэх хэсэгт байрлах нууц үг мартсан хэсэг рүү орж байгууллагын регистрийн дугаараар бүртгэлтэй цахим шуудангийн хаяг руугаа шинэчилсэн нууц үгээ авч сэргээх боломжтой.

14. Танай байгууллагын нэр болон мэдээлэл тус сайтаас олдохгүй бол хэнд хандах вэ?

- Танай байгууллагын мэдээлэл олдохгүй байвал membership@mongolchamber.mn цахим шуудангийн хаяг болон 7727-7070 /2/ утсаар (ажлын өдрүүдэд 09:00 - 17:00 цагийн хооронд) Гишүүнчлэлийн газарт хандан шийдвэрлүүлнэ.

15. Хуурамч, худал агуулгын талаарх мэдээллийг бидэнд хэрхэн өгөх вэ?

- Та TradeMongolia.MN вэб сайтын хөлний цэсэнд байрлах санал, хүсэлт цэсийг ашиглан хуурамч, худал, оюуны өмчийн зөрчилтэй агуулгын талаарх мэдээллийг бидэнд илгээх боломжтой. Эсвэл 7727-7070 /2/ утсаар (ажлын өдрүүдэд 09:00 - 17:00 цагийн хооронд) Гишүүнчлэлийн газарт хандана уу. Баярлалаа.